



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум,  
7-р баг, Жинст 0, Утас/Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 253

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА А.АЛТАНХУЯГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлт, шийдвэрийг хүргүүллээ.

Аудитаар өгсөн шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлж биелэлтийн ирүүлнэ үү.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



07030279

Боловсруулсан:  
Хянасан:  
Хувь: 2



Б.Цэцэгмаа 99488754  
Г.Энхдэлгэр 99002291

# ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/07/-НА-СТА-ТТЗ

|                                                                                      |                                                                                                         |               |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|---------------|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Алтай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор:                                                                               | Х.Түвшинбаяр  |
|                                                                                      | Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> |               |
|                                                                                      | Аудитын менежер:                                                                                        | Д.Эрдэнэчимэг |
|                                                                                      | Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>   |               |
|                                                                                      | Ахлах аудитор:                                                                                          | Б.Цэцэгмаа    |
|                                                                                      | Утас: 99177546 Цахим хаяг: <a href="mailto:Tsetsegmaab@audit.gov.mn">Tsetsegmaab@audit.gov.mn</a>       |               |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

|                                                                                        |    |
|----------------------------------------------------------------------------------------|----|
| 1. Аудитын гэрчилгээ .....                                                             | 2  |
| 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....         | 4  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/ .....             | 4  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/ .....          | 5  |
| 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ .....              | 6  |
| 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ ... | 7  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/ .....                     | 7  |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/ .....                     | 8  |
| 1. Аудитын тайлан .....                                                                | 9  |
| 3.1. Ерөнхий зүйл .....                                                                | 9  |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                                   | 9  |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                                        | 10 |
| 3.4 Материаллаг байдал .....                                                           | 10 |
| 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга .....                                    | 10 |
| 3.5.1 Орлогын данс .....                                                               | 11 |
| 3.5.2 Зардлын данс .....                                                               | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....                                   | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....                              | 13 |
| 3.8 Аудитын гол асуудал .....                                                          | 13 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....                                       | 13 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                                                  | 13 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                                         | 14 |
| 4. Аудитын илрүүлэлт .....                                                             | 14 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                                      | 16 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....                 | 16 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт            |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТТЗ      | Төсвийн төвлөрүүлэн захирагч                                |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                       |
| ИТХ      | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                                |
| ЗДТГ     | Засаг даргын тамгын газар                                   |
| ЭМТ      | Эрүүл мэндийн төв                                           |
| ЕБС      | Ерөнхий боловсролын сургууль                                |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                                   |
| СХС      | Сум хөгжүүлсэн сан                                          |



ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
А.АЛТАНХУЯГ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 185  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020511

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

| Код:  | Тайлангийн үзүүлэлт                                                   | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|-------|-----------------------------------------------------------------------|-----------------------|------------------------|
| 1     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН                                               | 3,187,080.0           | 3,522,558.4            |
| 31    | МӨНГӨН ХӨРӨНГӨ                                                        | 936,429.5             | 800,808.1              |
| 33    | АВЛАГА                                                                | 953,524.2             | 1,166,330.4            |
| 35    | БАРАА МАТЕРИАЛ                                                        | 1,294,591.3           | 1,555,419.9            |
| 36    | НӨӨЦИЙН БАРАА                                                         | 2,535.0               | 0.0                    |
| 2     | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН                                           | 34,387,559.8          | 40,288,646.7           |
| 39    | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                                                        | 34,387,559.8          | 40,288,646.7           |
| 39200 | Биет хөрөнгө                                                          | 31,428,897.3          | 37,257,052.0           |
| 39300 | Биет бус хөрөнгө                                                      | 2,958,662.5           | 3,031,594.6            |
| 3     | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II                                           | 37,574,639.8          | 43,811,205.1           |
| 4     | НИЙТ ӨР ТӨЛБӨР                                                        | 22,178.1              | 233,893.1              |
| 41    | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                                             | 22,178.1              | 233,893.1              |
| 41300 | Өглөг                                                                 | 22,178.1              | 231,418.1              |
| 41400 | Урьдчилж орсон орлого                                                 | 0.0                   | 2,475.0                |
| 5     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                                              | 37,552,461.6          | 43,577,312.1           |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо                                           | 37,552,461.6          | 43,577,312.1           |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 13,232,930.4          | 13,260,910.4           |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/                                                   | 0.0                   | 1,872,911.3            |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн                                                  | 8,462,141.2           | 12,654,464.9           |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 15,857,389.9          | 15,789,025.4           |
| 6     | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           | 37,574,639.8          | 43,811,205.1           |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|------|----------------------------------------------------------|-----------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                          | 24,039,332.4          | 25,155,259.7           |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО                                          | 928,131.8             | 1,075,646.2            |
| 110  | Орлогын албан татвар                                     | 740,087.1             | 767,056.7              |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                          | 740,087.1             | 767,056.7              |
| 113  | Хөрөнгийн албан татвар                                   | 4,567.0               | 23,164.7               |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 183,477.7             | 285,424.8              |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 4,298,061.7           | 8,194,378.2            |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              | 4,298,061.7           | 8,194,378.2            |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 18,813,138.9          | 15,885,235.3           |
| II   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                              | 21,407,098.5          | 20,036,398.1           |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 21,407,098.5          | 20,036,398.1           |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 16,805,796.3          | 19,477,655.8           |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 9,357,149.4           | 10,325,435.0           |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 1,149,421.1           | 1,348,445.1            |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 1,738,750.6           | 1,960,686.8            |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 220,638.7             | 422,742.5              |
| 2105 | Нормативт зардал                                         | 298,994.3             | 1,341,992.7            |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 131,387.5             | 211,577.2              |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 6,245.3               | 3,175.2                |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,235,345.5           | 794,691.5              |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 1,667,863.9           | 3,068,909.8            |
| 212  | ТАТААС                                                   | 16,352.7              | 0.0                    |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 4,584,949.5           | 558,742.3              |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)                    | 2,632,233.9           | 5,118,861.7            |
| IV   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН                          | 0.0                   | 0.0                    |
| V    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                          | 433,245.1             | 977,004.9              |
| VI   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)          | 2,198,988.8           | 4,141,856.8            |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|------|----------------------------------------------------------|------------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)                   | 20,114,122.1           | 17,681,045.7           |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО                                          | 928,131.8              | 1,075,646.2            |
| 110  | Орлогын албан татвар                                     | 740,087.1              | 767,056.7              |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                          | 740,087.1              | 767,056.7              |
| 113  | Хөрөнгийн албан татвар                                   | 4,567.0                | 23,164.7               |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 183,477.7              | 285,424.8              |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж                            | 154,221.9              | 237,597.9              |
| 1181 | Газрын төлбөр                                            | 28,417.5               | 47,695.0               |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр                          | 838.3                  | 132.0                  |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 315,736.2              | 926,389.9              |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              | 315,736.2              | 926,389.9              |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 18,870,254.0           | 15,679,009.5           |
| II   | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 18,978,744.0           | 16,529,639.2           |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 18,978,744.0           | 16,529,639.2           |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 14,328,357.1           | 16,011,186.4           |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 9,244,314.9            | 9,847,641.6            |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 1,156,100.7            | 1,331,869.2            |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 1,803,380.8            | 1,975,481.3            |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 278,506.7              | 356,988.5              |
| 2105 | Нормативт зардал                                         | 283,786.4              | 300,716.8              |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 153,613.5              | 265,424.1              |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 4,481.7                | 3,047.6                |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 380,092.3              | 656,028.2              |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 1,024,080.1            | 1,273,989.2            |
| 212  | ТАТААС                                                   | 23,000.0               | 0.0                    |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 4,627,386.9            | 518,452.8              |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)      | 1,135,378.1            | 1,151,406.5            |
| V    | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                | 512,785.2              | 990,373.8              |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                         | 512,785.2              | 990,373.8              |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      | 512,785.2              | 990,373.8              |
| VI   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)    | -512,785.2             | -990,373.8             |
| VII  | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН   | 0.0                    | -296,654.0             |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               | 0.0                    | 296,654.0              |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)        | 622,592.8              | -135,621.3             |
| 101  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 313,836.6              | 936,429.5              |
| 20   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 936,429.5              | 800,808.1              |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|-------------------------------------------------|-----------------------------------------|-----------------------|------------------------|
| 1    | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 35,360,791.4                            | 0.0                   | 35,360,791.4           |
| 2    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 12,613.3                                | 0.0                   | 12,613.3               |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 35,373,404.7                            | 0.0                   | 35,373,404.7           |
| 4    | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -25,605.1                               | 0.0                   | -25,605.1              |
| 5    | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0.0                                     | 0.0                   | 0.0                    |
| 6    | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0.0                                     | 0.0                   | 0.0                    |
| 7    | Өмчид гарсан өөрчилөлт                          | 5,673.3                                 | 0.0                   | 5,673.3                |
| 8    | Зарласан ногдол ашиг                            | 0.0                                     | 0.0                   | 0.0                    |
| 9    | Тайлант үеийн үр дүн                            | 2,198,988.8                             | 0.0                   | 2,198,988.8            |
| 10   | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 37,552,461.6                            | 0.0                   | 37,552,461.6           |
| 11   | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 37,552,461.6                            | 0.0                   | 37,552,461.6           |
| 12   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 50,466.8                                | 0.0                   | 50,466.8               |
| 13   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 37,602,928.5                            | 0.0                   | 37,602,928.5           |
| 14   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -68,364.5                               | 0.0                   | -68,364.5              |
| 15   | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 27,980.0                                | 0.0                   | 27,980.0               |
| 16   | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0.0                                     | 0.0                   | 0.0                    |
| 17   | Өмчид гарсан өөрчилөлт                          | 1,872,911.3                             | 0.0                   | 1,872,911.3            |
| 18   | Зарласан ногдол ашиг                            | 0.0                                     | 0.0                   | 0.0                    |
| 19   | Тайлант үеийн үр дүн                            | 4,141,856.8                             | 0.0                   | 4,141,856.8            |
| 20   | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл           | 43,577,312.1                            | 0.0                   | 43,577,312.1           |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

| Код  | Үзүүлэлт                                                 | Төлөвлөгөө    | Гүйцэтгэл     |
|------|----------------------------------------------------------|---------------|---------------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 16,793,784.20 | 16,548,322.94 |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 15,976,474.20 | 15,763,085.42 |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 15,603,750.90 | 15,394,201.02 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 9,608,727.50  | 9,513,757.72  |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 1,272,607.30  | 1,229,396.32  |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 1,960,546.50  | 1,945,466.68  |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 200,780.40    | 193,697.26    |
| 2105 | Нормативт зардал                                         | 317,918.30    | 300,581.64    |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 758,977.00    | 758,573.18    |
| 2107 | Томилот, зочны зардал                                    | 5,318.00      | 3,047.60      |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 100,744.20    | 99,996.03     |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 1,378,131.70  | 1,349,684.59  |
| 212  | ТАТААС                                                   | 20,000.00     | 20,000.00     |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад өгөх татаас                 | 20,000.00     | 20,000.00     |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 352,723.30    | 348,884.40    |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг                                   | 352,723.30    | 348,884.40    |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                         | 420,310.00    | 488,583.52    |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               | 397,000.00    | 296,654.00    |
| III  | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 16,793,784.20 | 16,667,968.34 |
| 31   | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                                  | 12,247,245.30 | 12,086,821.31 |
| 32   | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                           | 4,145,538.90  | 4,173,333.26  |
| 33   | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ             |               |               |
| 35   | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                    | 401,000.00    | 407,813.76    |
| 4    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         |               | 408,534.99    |
| 5    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        |               | 528,180.39    |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

| Код  | Үзүүлэлт                                                 | Тайлант он |
|------|----------------------------------------------------------|------------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 256,443.63 |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 256,443.63 |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 249,503.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 9,178.00   |
| 2105 | Нормативт зардал                                         | 1,213.40   |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 36,752.20  |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 173,100.95 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 29,258.46  |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 6,940.63   |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг                                   | 800.00     |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                            | 6140.63    |
| I    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 256,443.63 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 256,443.63 |

## **1. Аудитын тайлан**

### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/103 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн сумынхаа хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, шадар туслагч нь байхад оршино” гэсэн эрхэм зорилго тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 17,604.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 352.1 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 20,036.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 400.7 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга**

Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.5 хувиар буюу 6,236.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 936.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 800.8 сая төгрөг болж, 135.6 сая төгрөгөөр буурсан байна. Нийт мөнгөн хөрөнгийн 665.0 сая нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд үлдсэн 135.8 сая төгрөг нь арилжааны банк дахь ӨЭМТ болон ААТҮГ, УТҮГ-ын харилцах дансанд байршиж байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 953.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,166.3 сая төгрөг болж, 212.8 сая төгрөгөөр өссөн. Авлагын үлдэгдэлд ажиллагсадтай холбогдсон авлага 5.6 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлага 62.8 сая төгрөгийн, зээлийн авлага 671.6 сая төгрөгийн, дансны авлага /ТӨҮГ/ 0.4 сая төгрөгийн, татвар НДШ-ын авлага /ТӨҮГ/ 0.07 сая төгрөг, байгууллагаас авах авлага 331.3 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 94.3 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Байгууллагаас авах авлага нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн эргэлтийн хөрөнгийн түргэн хөрвөх

чадварыг бууруулж цаашид төлөгдөхгүй тохиолдолд үргүй зардал бий болох сөрөг үр дагавартай.

Бараа материалын эхний үлдэгдэл 1,294.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,555.4 сая төгрөг болж, 260.8 сая төгрөгөөр өссөн, нөөцийн барааны эхний үлдэгдэл 2.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материал тайлант оны эцэст 1,555.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд бараа материал 2,604.9 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүний 67 хувь буюу 1,746.5 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн бол 30 хувь буюу 779.4 сая төгрөгийн бараа материалыг хандиваар, 3 хувь буюу 79.0 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан бол 2,346.7 сая төгрөгийн бараа материал хасагдаж оны эцэст 1,555.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 42,456.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 49,483.5 сая төгрөг болж, 7,026.7 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 616.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 4,341.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар, 4,909.8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, бусад ангилалд 1,102.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээр нийт 10,970.1 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 380.9 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 3,278.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бусад ангилалд 283.8 сая төгрөгийн нийт 3,943.5 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөд 4,437.8 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан ба шилжүүлсэн болон акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл болох 3,273.4 сая төгрөгийг дансны хасалт хэсэгт тайлагнасан байна.

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 22.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 233.9 сая төгрөг болж, 211.7 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 9.4 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг, 181.0 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 40.9 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг 2.5 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 37,552.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 43,577.3 сая төгрөг болж, 6,024.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөөр 50.5 сая төгрөгийг залруулж, хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 12,654.5 сая төгрөг болсон байна.

### **3.5.1 Орлогын данс**

Тайлант онд 1,075.6 сая төгрөгийн татварын орлого, 926.4 сая төгрөгийн татварын бус орлого, 20,166.5 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 22,168.5 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

### **3.5.2 Зардлын данс**

Тайлант онд 20,036.4 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 977.0 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

### 3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Есөнбулаг сумын ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын “Сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай” 01 дүгээр тогтоолд зааснаар Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 1,026.4 сая төгрөгийн татварын, 68.9 сая төгрөгийн татварын бус нийт 1,095.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,149.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 105 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс хог хаягдлын хураамжийн орлого тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд дээд шатны төсөв захирагчдаа тус тус хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийг 16,793.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрт зориулан 16,793.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 15,976.5 сая төгрөгийг урсгал зардалд, 420.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 397.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 12,247.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 3,725.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 420.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 280.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжих, 121.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан, орон нутгийн төсвийн эх үүсвэрээс авах санхүүжилтийг 29.1 сая төгрөгөөр (сумын ЗДТГ), орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс авах санхүүжилтийг 81.5 сая төгрөгөөр илүү авчээ. Цаашид зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үнэн зөв тодорхойлон батлагдсан төсвийг баримталж ажиллах шаардлагатай.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,548.3 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь урсгал зардлыг хэмнэж нэгж байгууллагын төсвөөс 184.9 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл буюу хэмнэлтийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой.

Төсвийг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 256.4 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 85.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 170.9 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. Нэмэлт санхүүжилтийн орлогыг урсгал зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 150 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлээгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт хэмнэлтийн тайлбарын хамт хэсэгт тус оны 4 дүгээр улирлын мэдээллийг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

**Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 17.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 381.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангаар өгөгдсөн шийдвэрээс 367.2 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулаагүй байна. Энэ нь тус төвлөрүүлэн захирагчид нэгтгэгддэг нэгж байгууллагуудын татварын цахим системийн илүү төлөлттэй холбоотой бөгөөд энэ онд нэгж байгууллагын удирдлагад үүссэн зөрүүг арилгах албан шаардлага хүргүүлсэн тул нэгтгэсэн тайлангаар давхардуулан шийдвэр өгсөнгүй.

### **Харьяа нэгж байгууллагын тухайд:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчдад нэгтгэгдэг нэгж байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

Өмнө онуудад хийгдсэн санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгөгдсөн шийдвэрээс сумын ЗДТГ-ын 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 35.5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, энэхүү шийдвэрийг заасан хугацаанд хэрэгжүүлээгүйд хүргүүлсэн хариуцлага оногдуулах албан шаардлагын биелэлт, сумын ОНХС-ийн 2.6 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдлийг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр тус сумын ОНХС-ын дансанд төвлөрүүлж төлбөрийн актын биелэлтийг тус тус ТТЗ-ийн аудитын хугацаанд гаргуулан авч биелэлтийг хангалаа.

Харин манай байгууллагаас 2020 онд “Аймгийн хэмжээний усны эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнэ”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 11/163 дугаартай 34.8 сая төгрөгийн төсвийн орлого болгох тухай төлбөрийн актын үлдэгдлийг хэрэгжүүлээгүй, шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх ёстой байсан боловч өнөөдрийг хүртэл хэрэгжүүлээгүй байна. Гэвч тус төлбөрийн актыг хариуцуулан тогтоосон албан тушаалтнууд солигдсон байх тул ТТЗ-ын аудитаар тус төлбөрийн актыг хэрэгжүүлэн ажиллах албан бичиг хүргүүлээ.

Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитын шийдвэрийг хэрэгжилт, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй.

### **4. Аудитын илрүүлэлт**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 20 төсвийн байгууллага, 3 өрхийн эрүүл мэндийн төв, 1 төрийн өмчит үйлдвэрийн газар, 1 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 3 тусгай сангийн нийт 28 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 18 төсөвт байгууллага, 3 өрхийн эрүүл мэндийн төв, 1 төрийн өмчит үйлдвэрийн газар, 1 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 1 санд дүгнэлт гаргаж, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан ба 2 байгууллага (сумын ЗДТГ, Оюуны түлхүүр бага сургууль) аудитад хамрагдаагүй байна. Оюуны түлхүүр бага сургуулийн тухайд татан буугдсан ба санхүүгийн нэгтгэсэн тайланд тус байгууллагын зөвхөн хөрөнгө нь нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 14, “Хязгаарлалттай” (сумын ИТХ, 4 дүгээр сургууль, 3 дугаар цэцэрлэг, 7 дугаар цэцэрлэг, 11 дүгээр цэцэрлэг, Хантайшир өргөө цогцолбор цэцэрлэг, сумын СХС, Алтайн тохижилт үйлчилгээний газар, Алтай хотын цогц үйлчилгээний газар, Марал Алтай ӨЭМТ ) 10 дүгнэлт өгсөн байна.

### **Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан тусгай сан болон нэгж байгууллагуудад 2,064.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,405.5 сая төгрөгийн алдааг залруулж, 48.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 575.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, ажлын хариуцлага алдсан 5 албан тушаалтанд сахилгын хариуцлага оногдуулах албан шаардлага өгч, үйл ажиллагааг сайжруулах 9 зөвлөмжийг хүргүүлж 35.0 сая төгрөгийн зөрчлийг УАГ-т уламжилсан байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

#### **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 29.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 2 албан тушаалтанд хариуцлага оногдуулах албан шаардлага хүргүүллээ.

#### **4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

##### **Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:**

Аудитаар Есөнбулаг сумын төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд залруулга хийгээгүй болно.

##### **Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:**

Аудитаар түүвэрт хамрагдсан санд залруулга хийгээгүй болно.

#### **4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

##### **Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### **4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага**

##### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:**

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг гаргахад хог хаягдлын хураамжийн орлого 29.8 сая төгрөгөөр тасарсан нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Есөнбулаг сум нэртэй шилэн дансны цахим хуудаст улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлээгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт хэмнэлтийн тайлбарын хамт хэсэгт тус оны 4 дүгээр улирлын мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.2.5-т "Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа" 6.3.3-т "Төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл,

санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төсөв захирагч болон нягтлан бодогчид сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлага хүргүүлээ.

#### Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

Аудитаар түүвэрт хамрагдсан санд албан шаардлага өгөгдөөгүй болно.

#### 4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

#### 5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д                                                              | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |      | Үүнээс    |     |               |     |                 |      |         |     |
|------------------------------------------------------------------|-------------------------------------|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|------|---------|-----|
|                                                                  |                                     |                      |      | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |      | Зөвлөмж |     |
|                                                                  |                                     | Тоо                  | Дүн  | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн  | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал                            |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| Төсвийн төвлөрүүлэн захирагч                                     |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| Есөнбулаг сумын Төвлөрүүлэн захирагч                             |                                     | 3                    | 29.8 |           |     |               |     | 3               | 29.8 |         |     |
| Түүвэрт хамрагдсан байгууллага                                   |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| ОНХС                                                             |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| БХНСБХС                                                          |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| Дүн                                                              |                                     | 3                    | 29.8 |           |     |               |     | 3               | 29.8 |         |     |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| Төсвийн төвлөрүүлэн захирагч                                     |                                     | 1                    |      |           |     |               |     | 1               |      |         |     |
| Дүн                                                              |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| ОНХС                                                             |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| БХНСБХС                                                          |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| Дүн                                                              |                                     |                      |      |           |     |               |     |                 |      |         |     |
| Нийт дүн                                                         |                                     | 4                    | 29.8 |           |     |               |     | 4               | 29.8 |         |     |



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

20 22 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 01/186

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг гаргахад хог хаягдлын хураамжийн орлого 29,768.7 мянган төгрөгөөр тасарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>-т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг), санхүүгийн албаны дарга (Ц.Жамъян) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ  
Б.ЦЭЦЭГМАА

8217144139  
ДЮА000000018301

<sup>1</sup> Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Утас:70484030

070428833



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

20 22 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02/180

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Есөнбулаг сумын шилэн дансны цахим хуудаст улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлээгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт хэмнэлтийн тайлбарын хамт хэсэгт тус оны 4 дүгээр улирлын мэдээллийг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.2.5-т "Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа" 6.3.3-т "Төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.1 дэх заалт /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг), санхүүгийн албаны дарга (Ц.Жамъян) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ  
Б.ЦЭЦЭГМАА



<sup>1</sup> Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Утас:70484030

07042688



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

20 22 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 03/190

Алтай хот

┌ САХИЛГЫН ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ ┐  
ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч Ц.Даваажаргалд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Баасандаш)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ  
Б.ЦЭЦЭГМАА

8217144139

ДЮА0050 0018301

<sup>1</sup> Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

07040690



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 04/186

Алтай хот

┌ САХИЛГЫН ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ ┐  
ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Баасандашид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ  
Б.ЦЭЦЭГМАА

8217144139

ДНУА000000018301

<sup>1</sup> Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

07049593



ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
А.АЛТАНХУЯГ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn


2022.03.25 № 254  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т


Биелэлт ирүүлэх тухай

Танай байгууллага нь манай байгууллагаас 2020 онд “Аймгийн хэмжээний усны эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнэ”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 11/163 дугаартай 34,800.0 мянган төгрөгийн төсвийн орлого болгох тухай төлбөрийн актын үлдэгдлийг хэрэгжүүлээгүй, шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх ёстой байсан боловч өнөөдрийг хүртэл хэрэгжүүлээгүй байна.

Иймд уг шийдвэрийг биелүүлэн хэрэгжилтийг албан бичгээр нотлох баримтын хамт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.ТҮВШИНБАЯР



07020521